



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон. Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2017 10.05 № 17

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ  
ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний үйлдвэрээ сэргээн хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн болон түүний дотор арьс, ширний үйлдвэрлэлийг дэмжих, нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэгдсэн арга хэмжээг үе шаттай авахаар холбогдох тогтоолыг батлан гаргасан байна.

Дээр дурдагдаж буй арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоол, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол, “Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 249 дүгээр тогтоол, “Арьс, ширний үйлдвэрлэлийн төсөл дэмжих тухай” Улсын Их Хурлын 2014 оны 198 дугаар тогтоолууд батлагдан гараад 3-6 жил болсон ч хэрэгжилт нь хангагдаагүй байна.

Арьс, ширний үйлдвэрүүдийн технологийн шинэчлэл хийх, дэд бүтцийг байгуулах, нүүлгэн шилжүүлэх ажлыг 2011 оноос эхлэн үе үеийн Засгийн газарт даалган холбогдох арга хэмжээг авч ажиллахыг УИХ-аас үүрэг чиглэл өгч байжээ.

Тус үйлдвэржүүлэлтийг бий болгох асуудлыг 2008 оноос эхлэн Дархан-Уул, Орхон, Ховд, Хөвсгөл, Нийслэлийн Налайх, Багануур, Багахангай гэх мэт аймаг, дүүргүүдэд байгуулахаар холбогдох төвшинд яригдсан ч нэгдсэн шийдэлд хүрэлгүй цаг хугацаа алдсаар байна.

Мөн УИХ-ын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолын 2.5 дахь заалтаар арьс ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга, хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах үүрэг өгөгдсөн нь өнөөг хүртэл биелэгдээгүй.

Иймд Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход

0000000028

зориулагдсан мөнгөн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, түүний үр дүнд бий болсон ажлын байрын тоо, үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний хэмжээ.

2. Арьс, ширний үйлдвэрийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах талаар УИХ-ын тогтоолоор өгөгдсөн үүргийн хэрэгжилт, энэ чиглэлд ямар арга хэмжээ авсан, хугацаа тогтоон заасан үүргийг хэзээ, хэдэн онд бүрэн хийж дуусгах.


3. Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 356 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг "Шар хөцийн хоолой" гэдэг газарт "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк" байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ ажил 2018 онд эхлэх эсэх, тус пркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлыг хэрхэн хийхээр төлөвлөж байгаа талаар.

4. Засгийн газар нь малын удмын санг хамгаалах, эрүүлжүүлэх, үйлдвэр угсааг сайжруулах, ашиг шим сайтай малын тоог нэмэгдүүлэхтэй холбоотой ямар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа, малын гаралтай түүхийн эдийг боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлж нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар хэрхэн бодлого боловсруулан ажиллаж байгаа.

5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх, хэтийн төлөвлөлт, хөгжлийн чиглэлд баримталж буй бодлого үйл ажиллагааны талаар тус тус хариу өгнө үү.

Асуулгыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасны хугацаанд албан бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б ӨНХ-АМГАЛАН